



МИК ХОЛДИНГ ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20... оны ... сарын ... өдөр

№ .../...

Улаанбаатар хот

### Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар-зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
  - 1.1. 2.2-г “Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14210/, Энхтайваны өргөн чөлөө 19, 13-р давхар” гэснийг “Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу /15160/, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот” гэж өөрчлөх;
  - 1.2. 9.4-г “ХЭХ-ын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг ТУЗ-ийн ээлжит бус сонгуулиар сонгоно. Харин бүрэн эрх нь хугацаанаас өмнө дуусгавар болсон гишүүний оронд ажиллах этгээдийг ТУЗ томилно.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах;
  - 1.3. 9.6-г “ТУЗ дараах тохиолдолд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлыг шийдвэрлэж болно. Үүнд:
    - 9.6.1. Гурван сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллах боломжгүй болсон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;
    - 9.6.2. ТУЗ-ийн гишүүнд анх санал болгосон этгээдээс төлөөллөө өөрчлөх талаар тодорхой санал гаргасан;
    - 9.6.3. Эрүүл мэндийн шалтгаанаар ажиллах боломжгүй болсон тухай мэдэгдсэн;
    - 9.6.4. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон;
    - 9.6.5. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр сураггүй алга болсонд тооцогдсон;
    - 9.6.6. Нас барсан, эсхүл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нас барсанд тооцогдсон;
    - 9.6.7. ТУЗ-ийн гишүүн ёс зүйн ноцтой зөрчил гаргасан;
    - 9.6.8. Удаан хугацаагаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бусад тохиолдол.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах;
  - 1.4. “Энэ дүрмийн 9.6-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн гишүүдийн 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй болсон буюу ажиллахгүй болсон тохиолдолд ТУЗ-ийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүйд тооцож ХЭХ-ыг хуралдуулна.” гэж 9.6<sup>1</sup> заалтаар нэмж оруулах.
2. Энэ тогтоолын 1-г заасан нэмэлт, өөрчлөлтийн талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх болон улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Ч.ХАШЧУЛУУН